



Манмин Мэдээг уншиж мөн Эхлэл бүлгийн Сургаалыг сонсож суухдаа

2004 оны хавар би Чун-нам мужын Дэйжонд сайн мэдээ тарааж байх үед юм. Сүмийн итгэчийн гэрт очоод буцаж ирэхдээ гэрийнхээ гадаа Манмин Мэдээ сонинг олж харлаа. Түүнийг авч гэрт орон уншихад И Жаерок пасторын сургаал болон түүний залбирлаар дамжуулан олон тэмдэг гайхамшигд бий болсон тухай болон аймшигт өвчнүүд элгэрсэн тухай олж мэдээд маш их гайхсан юм.

Тэгээд би дотроо, "Ийм Бурханы хүчит үйлсээр дүүрэн сүмийг хүмүүс яагаад ийм буруу ойлголттой байдаг юм бол?" хэмээн бодогдож, энэ сүмийн талархлыг үнэн мөндөр мэдэж авахын тулд би сүмийн интернэт сайт (www.manmin.org) хаая руу нь орж үзлээ. Бүгдийг нь үзэж, уншиж танилцаад бусад сүмүүдээс ялгагдах ямар ч онцгой зүйл олж харсангүй. Харин ч бүр тэр сайт дээрх мэдээлэлүүдийг уншиж судлах тусам ивээлийг авч байлаа.

Тийнхүү үзэж байхдаа би Доктор И Жаерок пасторын Эхлэл бүлгийн тайлбар сургаалыг сонсох болсон юм. Хэмжээ хязгааргүй мэт бүтээлийн нууцуудыг маш тодорхой тайлбарлаж буй сүнсэлэг энэ сургаалд би бүр автаж орхисон байлаа. Түүний айлдсан сургаалуудыг сонсож байхдаа, "Угийн Бурхан", "Еден Цэцэрлэг", "Сайн Мууг мэдүүлэгч модыг тавьсны учир", "Пирамид", болон "Динозавр" хэмээх сургаалуудыг сонсоод улам биширч, биеэр уулзаагүй пастор боловч би хувьдаа дэмждэг байлаа.

Сургаалыг сонсож байхад үзүүлж өгдөг гайхамшигт солонгод, Муан амгат ус, Эрх мэдэлт хүчт гар алчуур ба ододын хөдөлгөөнүүд гэх мэт гайхамшигт үзлийсийг

үзэж хараад үнэхээр сэтгэл их хөдлөсөн юм. Эдгээр үзсэн сонссон зүйлсээр дамжуулан миний урьд өмнө төсөөлөөгүй байсан сүнсэлэг ертөнц рүү хөтлөн дагуулсан юм. Ингэж үнэнийг ойлгож мэдрэх боломжтой болсондоо би туйлын их баяртай байв.

Итгэлээрээ бөөрний дутагдал өвчнөөсөө эдгэрч, Бурханы сургаалыг гүнзгий судлахад,

2004 оны намар, миний гэдэс хэвлийн хэсгээр маш хүчтэй өвдөж, эмнэлэг рүү хүргэгдсэн бөгөөд намайг бөөрний дутагдал ба чулуужилттай гэсэн онош гарав. Хэдийгээр эмнэлгийн анхны тусламжийн төвд эмчилгээ хийсэн ч хоёр гурван долоо хоногийн дараа дахин өвчтэй болсон тул цэргийн албанаасаа гарах болов. Христч гэр бүлд төрж өссөн ч гэсэн нэг хэвийн хэлбэр төдий итгэлийн амьдралаар амьдарч байснаа ихэд гэмшин өвчнөөсөө эдгэрэх гэсэн сэтгэлээр Бурхандаа ойртон ирсэн юм. Яг энэ л үед машаг барих гэсэн зүрх сэтгэлийн дуудлагыг хүлээн аваад 7 хоногийн турш мацаг барьж залбирал хийж байх үед Эзнийн боолоор дуудагдсан юм. Тэр үед би ч залуу байсан болохоор бүх л зүйлээ орхин явахад маш хүнд байсан ба Эзнийн боолын замаар хүний хувьд энэ нь хэцүү зүйл байв. Эцэст нь би өвчнөөсөө эдгэрч чадахгүй байсан болохоор "Өвчнийг минь эдгээж өгч Ариун сүнслийн хүч нөлөөг мэдрүүлбэл Эзнийн боолын замаар явъя" амласан юм.Түүний дараа 3 хоногийн мацаг барихаар төлөвлөсөн юм. Дараагийн өдөр нь би залбирал дунд Ариун Сүнслийн галыг авч өвчнөөсөө эдгэрсэн юм. Тэнгэрээс гэрэл цацран бууж ирж байгааг ч бүртэл би харж, эцэст нь би харьтайгаар Эзнийн боол болохоор шийдэв.

Тэгээд би 40 гаруй насандаа олон мянган хүмүүс цугларсан том сүмийн хариуцагч пастор амархан болж чадсан юм. Гэвч залбирал ба сургаал үгийн хүчээр дутмаг надад сүмийн үйл ажиллагаа явуулахад хэцүү зүйл их тохиолддог байлаа. Ингэж байх зуур нэгэн танил хүн маань намайг их сургуульд багшлах хүсэлт гаргасан ба тэрхүү саналыг хүлээн авав. 2005 оны тавдугаар сард би сүм удирдах пасторын үүрэгт ажлаа орхиж хүсэн хүлээж байсан их сургуульд багшлах гэсэн нь тийм ч амархан бүтээнгүй. Тэгээд би Соулд 2 жилийн турш итгэлийн амьдралаар чөлөөтэй болж, Манмин төв сүмийн Ням гаригын үдээс хойш мөргөл болон, Даниелын залбирлын цаг, Баасан гаригын оройн мөргөлд оролох болж, 2008 оны гуравдугаар сард би гишүүнээр бүртгүүлэн оров.

Эзнийн боолын үүрэгт ажлаа умартсан байсандаа чин сэтгэлээрээ гэмшсэн нь

Би 1978 оны Хоёрдугаар сард Ёнсей Их Сургуулийн бизнесийн удирдлагын мэргэжлээр төгсөөд ROTC (Reserve Officers' Training Corps) цэргийн офицерын алба хашиж, Уушигны хүчтэй сүрьеэ өвчтэй болсон тул цэргийн албанаасаа гарах болов. Христч гэр бүлд төрж өссөн ч гэсэн нэг хэвийн хэлбэр төдий итгэлийн амьдралаар амьдарч байснаа ихэд гэмшин өвчнөөсөө эдгэрэх гэсэн сэтгэлээр Бурхандаа ойртон ирсэн юм. Яг энэ л үед машаг барих гэсэн зүрх сэтгэлийн дуудлагыг хүлээн аваад 7 хоногийн турш мацаг барьж залбирал хийж байх үед Эзнийн боолоор дуудагдсан юм. Тэр үед би ч залуу байсан болохоор бүх л зүйлээ орхин явахад маш хүнд байсан ба Эзнийн боолын замаар хүний хувьд энэ нь хэцүү зүйл байв. Эцэст нь би өвчнөөсөө эдгэрч чадахгүй байсан болохоор "Өвчнийг минь эдгээж өгч Ариун сүнслийн хүч нөлөөг мэдрүүлбэл Эзнийн боолын замаар явъя" амласан юм.Түүний дараа 3 хоногийн мацаг барихаар төлөвлөсөн юм. Дараагийн өдөр нь би залбирал дунд Ариун Сүнслийн галыг авч өвчнөөсөө эдгэрсэн юм. Тэнгэрээс гэрэл цацран бууж ирж байгааг ч бүртэл би харж, эцэст нь би харьтайгаар Эзнийн боол болохоор шийдэв.

ММБТ-н бэлтгэл хөтөлбөрт оролцон богино хугацаагаар Африкийн Кения улсад сайн Бурхан миний сэтгэл зүрхийг удаа дараалан шалгаж байгаа мэт надад санагдаж байсан юм. Нэгэн өдөр, надад өөр нэгэн сүмээс маш сайн нөхцөлтэйгөөр манайд ирж ажиллаач гэсэн санал



Кот Дивори дахь тус нутгийн пасторуудын хамт

"Агуу хайраараа удирдсан Ебенезер Бурхандаа талархлыг өргөө"

Мүн Шинь хён Пастор (2-р их тойрог 14-2 бүлгийн удирдагч)

Доктор И Жаерок пастор болон Манмин Төв Сүм рүү хандсан тэмүүлэл минь улам хүчтэй болсон юм.

Удалгүй МанМин төв сүмд очин "Загалмайн Сайн Мэдээ", "Тэнгэрийн орон I ба II" ба "Там", хэмээх номууд болон "Итгэлийн Хэмжээ", "Атга сүнслий ертөнц", "Итгэлийг хэмжих нь" хэмээх сургаалуудын касетийг худалдан авч судалж эхлээ. Сургаалуудыг сонсож, номуудыг уншиж байхдаа гайхамшигт мэдрэмжүүд ба сэтгэл хөдлөм ивээлийг дүүрэн авч, энэ хугацаанд сайн мэдээ тарааж байхдаа мэдэрч байгаагүй сэтгэл ханамж авах үг сургаалыг улам шамдан судалж сүнс сэтгэлийн шинэ хүч чадлыг олж авав.

Тэгээд би 40 гаруй насандаа олон мянган хүмүүс цугларсан том сүмийн хариуцагч пастор амархан болж чадсан юм. Гэвч залбирал ба сургаал үгийн хүчээр дутмаг надад сүмийн үйл ажиллагаа явуулахад хэцүү зүйл их тохиолддог байлаа. Ингэж байх зуур нэгэн танил хүн маань намайг их сургуульд багшлах хүсэлт гаргасан ба тэрхүү саналыг хүлээн авав. 2005 оны тавдугаар сард би сүм удирдах пасторын үүрэгт ажлаа орхиж хүсэн хүлээж байсан их сургуульд багшлах гэсэн нь тийм ч амархан бүтээнгүй. Тэгээд би Соулд 2 жилийн турш итгэлийн амьдралаар чөлөөтэй болж, Манмин төв сүмийн Ням гаригын үдээс хойш мөргөл болон, Даниелын залбирлын цаг, Баасан гаригын оройн мөргөлд оролох болж, 2008 оны гуравдугаар сард би гишүүнээр бүртгүүлэн оров.

Нэгэн удаа интернэтээр Доктор И Жаерок пасторын сургаалыг сонсож байх зуур "Үүрэгт ажлаа хийж гүйцэтгээгүй бол там руу илгээгдэж магадгүй" гэдгийг олж мэдэв. Эзнийн боол мөргөлөө үүрэгт ажлаа хийгээгүйнхээ төлөө нулимс унагаан гэмшиж залбирч, хайр ба эрх мэдэлт хүчээр баялсан, эв нэгдэл бүхий анхны цуглаан шиг МанМин төв сүмийн Эзнийн боол болохыг би туйлын ихээр хүсэж байсан юм.

2011 онд Бурхан надад шинэ үүрэгт өгч 14-2-р бүлгийн залбирч, хайр ба эрх мэдэлт хүчээр баялсан ба энэ нь миний амьдралд бий болж байсан хамгийн агуу гайхамшигт явдал ба ерөөл билээ. Бурхандаа би чин сэтгэлээр талархан уйлан залбирч, одоо би бүлгийнхээ итгэгчдийг сайн анхааран хамгаалж байх нь надад туйлын баяр баясгалан бөгөөд Эзнийн хүсэн хүлээсэн чин үнэнч боол нь болохын тулд өнөөдөр ч гэсэн залбиран урагшилсаар байгаа билээ.

Манмин Мэдээ

Дугаар 13 2011 оны Долдугаар сарын 17

"Бурхан руу хандсан эрч хүч бялхдаг сүм!" Оросын хамгийн шилдэг "Ин Виктори" хэмээх Христийн хэвлэл мэдээллийн группын удирдагч нар Манмин Төв Сүм дээр айлчлан ирэв.



"Ин Виктори" хэмээх Орос хэл дээрх Христийн хэвлэл мэдээллийн томоохон группын үндэслэгч Ноён Сергей Велбовец гуай болон Ерөнхий редактор Сергей Сержиенко Манмин Төв Сүм дээр айлчлан ирж үзгээрээ дамжуулан МанМин Сүмийн сургаал ба ивээл дүүрэн дүр төрхийг дэлхий даяар тунхаглан тараах болно гэдгээ амлан хэлцэв. ■ Зураг 1: 4-р сарын 24нд Ням гаригын өглөөний Их мөргөлийн үеэр Ноён Сергей Велбовец Доктор И Жаерок пасторд талархлын жуух бичгийг гардуулан өгч байгаа нь ■ Зураг 2: Доктор И Жаерок пастортой хийсэн ярилцлага ■ Зураг 3: Баасан гаригын оройн мөргөл үеэр ■ Зураг 4: Эзэн дахин амилалтын барын үйл ажиллагаа ба Ариун зоогийн ёслол ■ Зураг 5: Манмин ТВ-ын захирал И Жон ху захирагчтай хийсэн ярилцлага ■ Зураг 6: Шүлхий өвчнөөс хамгаалалт хүртсэн Чүнчон Манмин сүмийн итгэчийн гэрт айлчлан очив.



Дөрөвдүгээр сарын 23-д тэд Манмин мэдээ сонинг сурвалжлагч нартай хулээн авалтын танхимд уулзаж сурвалжлага авав.

2011 оны Дахин амилалтын тоглолтыг үзээд танд ямар сэтгэгдэл төрөв?

Сергей Велбовец: (захирал) Эзэн агуу үйлсээ үйлдэж байсан тэр л үед очсон юм шиг санагдаж байна. Мөн бодит байдал ба сүнсэлэг ертөнцийг зэрэг дүрслэсэн байдал болон тэнгэр элчүүдийн дүрх төрхөөр дамжуулан Эзнийн чин сэтгэлийг мэдэрсэн билээ.

Сергей Сержиенко: (Ерөнхий редактор) Бродваед орж тоглохоор маш чадварлаг гайхамшигтай тоглолт байна. Энэ тоглолтыг 3D дүрс бичлэг болгон олон нийтэд гаргавал маш олон хүмүүс талархан үзэх болно хэмээн би бодож байна.

Доктор И Жаерок пастортой хийсэн ярилцлагын тухай Сергей Велбовец: Доктор И Жаерок пастораас асуусан асуулуудын хариулууд нь энгийн ба товч боловч цаанаа гүн утга агуулгатай байв. Энэ нь Бурханы зүрх сэтгэлийг хүмүүст дамжуулах

үйлчлэгч хүний байх ёстой дүр төрх мэт санагдав.

Сергей Сержиенко: Би маш олон пасторуудтай уулзаж байсан билээ. Ихэнх пасторууд Бурханы юу хүсч байгаагаас илүү тэд өөрсдийнхөө юуг хүсч байгааг илэрхийлжээ байдаг. Гэтэл Доктор И Жаерок пастор зөвхөн Бурханы юу хүсч байгаад л тулгуурласан байдаг ба тийм ч учраас тэрээр ийм олон хүчтэй үйлс ба тэмдэг гайхамшигуудыг бий болгосоор байна хэмээн бодож байна.

Манмин Сүмийн хэвлэл мэдээлэл, нийтлэлийн ажлын талаар Сергей Велбовец:

Талархалтай нь үргэлж дээд зэргийн өндөр түвшинд бэлтгэн гаргадаг нь гайхалтай. Дэлхий даяар маш олон хүмүүс МанМин сүмийн ийм ивээлээр дүүрэн төрх байдлыг хүсэн тэмүүлж байгаа тул илүү олон орны хэл дээр ном хэвлэлүүд болон нэвтрүүлүүд нь цацагдан тараагдаасай хэмээн хүсэж байна.

Сергей Сержиенко: Тийм, э! үнэхээр үнэн юм. Манмин сүмийн бүх үйл ажиллагаа ба итгэгчдийн итгэлийн амьдралыг илүү идэвхтэйгээр тараахыг хүсэж байна. Барууны орнуудад, Бурхан

руу хандсан халуун эрч хүч буурч байхад харин эндээс эрч хүчийг мэдэрч байна. МанМин сүмийн гишүүдийн өдөр тутмын амьдрал нь маш их онцгой юм. Ийм үлгэр жишээ болсон амьдралаар амьдарч буй итгэгч нартаа үнэхээр талархмаар байна.

Сергей Велбовец: Одоо үед маш олон сүмүүд ихэвчлэн чинээлэг амьдрал ба ерөөл нийгэм дэх үйлчлэл гэх зэрэг сэдвүүдээр онцлон дурьддаг. Харин Манмин сүмийн хувьд бол маш өөр бөгөөд "ариун байдал" гэдэг ганцхан үг сүмийн бүх үйл ажиллагаанд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг мэдэрсэн юм.

Үнэхээр олон гэрчлэлүүдийн учир утга

Сергей Велбовец: Манмин Төв Сүм нь үнэхээр амьд сүм юм. Итгэгч нарын амьдралд Бурханы үг амьд болон идэвхтэй байдлыг бий болгодог тул сайнаар нөлөөлж байдаг билээ. "Ин Виктори"-д нийтлэгдсэн МанМин сүмийн тэмдэг гайхамшигуудын тухай нийтлэлүүдээс хүмүүс уншиж байхад Ариун Сүнслийн бялхал ба ивээл хүртлээ гэж гэрчилцгээж байсан билээ.

“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд (11)

Малын саравчинд төрж, тэжээлийн тэвшинд хэвтсэн Есүс

“Тэр өдрүүдэд газар бүрд хүн амын тооллого явуулах тухай Цезарь Августын зарлиг гарчээ... тэр ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож тэжээлийн тэвшин дотор тавив. Учир нь дэн буудалд тэднийг хоноглуулах өрөө байсангүй” (Лук 2:1-7). Есүс бол Бурханы Хүү бөгөөд хаадын дээд Хаан болон эздийн дээд Эзэн билээ. (Филиппой 2:6; Илчлэлт 19:16).

Есүс нь гэм нүгэлт хүн төрөлхтний гэмийг уучлан цагаатгахын тулд үхжж, 3 хоногийн дараа үхлийн хүчнийг ялан дийлж дахин амилснаар бидэнд авралын хаалгыг нээж өгсөн билээ. Түүгээр ч үл барам Есүс энэ дэлхийд ирсэн үеэс эхлэн загалмайн зовлон эдлэх үеийн бүхий л үйл явц нь Бурханы агуу төлөвлөгөөний дагуу байсан юм. Мөн Есүс яагаад малын саравчинд төрж, малын тэжээлийн тэвшинд хэвтсэн ба амьдралынхаа бүхий л хугацаанд ядуу тарчиг байсны утга учир юу вэ?

1. Есүсийг Малын саравчинд төрөн тэжээлийн тэвшинд хэвтүүлсний учир шалтгаан

Лукан 2-р бүлэгт Есүсийн хэрхэн төрсөн тухай гаргагч ба Ариун Сүнсний хүчээр Есүсийг тээж буй Онгон Мариа нь түүний нөхөр Иосефын хамт хүн амын тооллогонд хамрагдахын тулд Бетлехем руу явдаг бөгөөд тэнд Мариа Есүсийг төрүүлдэг.

Бетлехем хотод хүрэлцэн ирэхэд маш олон хүмүүс дэн буудлын газруудаар дүрсэн байсан тул тухайн үед Мариа малын саравчинд Есүсийг төрүүлж тэжээлийн тэвшинд хэвтүүлэхээс өөр аргагүй байсан юм. Энэ нь Бурханы айлдсаны дагуу Есүс малын тэвшинд хэвтэнэ хэмээн дурдлагдсан байдаг.

Номлогчийн Үгс 3:18-д, “Хүн гэгч өөрсдөө адгуус юм гэдгээ танихуйцаар тэднийг Бурхан туршаасай” гэж хүмүүний хөвгүүдийн талаар бичсэн бөгөөд “хэмээн хэлсэн байдаг. Зарим хүмүүс, Библи дээр яагаад биднийг адгуустай зүйрлэж байгаа юм бол хэмээн гайхахагч байдаг ба энэ нь маш сонин зүйрлэл хэмээн болшоогоод билээ. Хэдий тийм боловч хүний харгис хэрцгий зан нь адгуус араатан амьтнаас ч илүү муухай авирадаг билээ.

Түүнийг бүх бүтээлийн дээд оргил, бүхнийг захирагч хүн өөрийн шуналт хүслээ биелүүлэхийн тулд аамуун байдлыг дэгдээж хүүхэд эмэгтэйчүүдийг ч алгалгүй алж хөнөөж, өрсөлдөөн хэрүүл маргаан, сэр ч байтугай эцэг эх, үр хүүхэд болон хамаатан талархуудаа алж хөнөөгөд билээ.

Бурхан анх хүн төрөлхтнийг бүтээн бий болгохдоо Өөрийн дүр төрхөөр ариун бас сайхнаар бүтээсэн билээ. Гэвч Адам гэм нүгэл үйлдсэнээр түүний бүхий л үр удам гэм нүгэлд унаж тэдний сүнс нь үхэхэд хүрсэн юм. Ингэж сүнс нь үхэж сэтгэл ба оюун ухаан, бие нь үлдэж, бие ба ялгаж чадвар бүхий амьтан адгуус мэт болж хувирсан юм. Тэгээд сэтгэлд нь аажим аажмаар гэм нүгэл нэвтрэн орох тусам улам өөрийн хүслээ гүйцэтгэхийн тулд төрөл бүрийн гэмийг үйлдэн амьдардаг болсон юм.

Энэ мэт гэм нүгэлд хугтагдан адгуус араатан мэт болсон хүн төрөлхтөн яаж үзэсгэлэнтэй ариун тэнгэрийн улс орох билээ. Тиймээс бид энэ үзэсгэлэнтэй тэнгэрийн улсад орохын тулд анх Бурханы Өөрийн дүр төрхөөр бүтээж өгсөн цайлаган бөгөөд ариухан дүр төрхийг эргүүлэн олж авах хэрэгтэй юм. Яг үүний төлөө л Есүс энэ дэлхий дээр төрөхдөө малын саравчинд төрсөн ба Тэрээр адгуус амьтнаас ялгаггүй байдал буй хүн төрөлхтнийг аврахын төлөө ирсэн билээ.

Тэгвэл Есүс тэжээлийн тэвшинд хэвтсэний утга учир нь Иоханы 6:51-д үзвэл “Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн нь энэ талхнаас идвэл, тэр монхдө амьдарна. Ерөнхийн аминь төлөө Миний өгөх талх бол Миний махан бие гэж айлдлаа” хэмээн байдагчлан хүн тэнгэрээс буун ирсэн амьд талхыг иднэ гэдэг нь Бурханы үг сургаалыг сонсоод, түүний дагуу үйлдэж өөрийн болгон авна гэсэн үг юм. Хүний махан бие нь хоол тэжээл идэж



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

байж амьдардаг шиг хүний сүнс ч сүнсний хоол тэжээл идэж байж амьдрах боломжтой. Есүс нь Бурханы үгээр махан биенийг өмсөн энэ газар дээр ирсэн билээ.(Иохан 1:14) Үг болох Есүс нь энэ газар дээр ирээд адгуус мэт хүн төрөлхтний амийн талх болсон юм. Өөрөөр хэлбэл Есүсээр дамжуулан хүн бүр өөрийн алдагдсан Бурханы дүр төрхийг буцаан олж авах боломжтой болсон юм. Тиймээс энэ зүйлийг ухааруулахын тулд Бурханаас Есүсийг малын тэжээлийн тэвшинд хэвтүүлсэн юм.

Мөн Номлогчийн Үгс 12:13-д, бидэнд, “Энэ бүхнийг сонордоод, дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна.” гэж айлдсан байдаг юм.Эндээс үзэхэд хүний үндсэн гол үүрэг нь Бурханы сургаал тушаалуудыг сонсож, мөн үйлсээр чанг сахих нь эрхэм чухал юм. Өөрөөр хэлбэл Бурханы үг болох Библи дээр хийгээрэй дагаарай гэснийг хийж дагаж, бүү үйлд,бүү хий гэснийг хийхгүй байх нь хүний гол үүрэг ба үүгээр дамжуулан бид өөрсдийн Бурханы алдагдсан дүр төрхийг сэргээх боломжтой билээ.

Зарим итгэгч нар, “Яаж Бурханы бүх тушаалуудыг даган сахиж чадах вэ? Итгэлийн амьдрал дэндүү хэцүү байна?” гэдэг ч Бурхан биднийг хүнд хэцүү байдалд оруулж хэцүү ийм тушаалууд ба сургаалуудыг айлдсан биш юм.

Энэ нь Бурхан Өөрийн хайрт хүүхдүүддээ хандан хэлж буй сургамж үг юм. Хайрт хүүхдүүддээ аймшигт там руу явуулахгүйн тулд “Бүү хий”, “Хая” хэмээн захиж, үзэсгэлэнтэй тэнгэрийн улс руу явуулахын тулд “Хий”, “Сахь” гэж гэрэл дотор үйлдэж, хийж, сахихыг мөн сургамжилдаг юм. Мөн бид энэ мэт үйлдэж, сахиснаар Бурханы хайрыг хүртэж, эрүүл энх, эд баялгын хувьд ч бүх тал дээр өрөөл хүртэж үргэлж аз жаргалтай амьдрах болдог юм.

Тиймээс та Төгс хүчит Бурханы Хүү яагаад энэ мэт малын саравчинд төрж, тэжээлийн тэвшинд хэвтсэний утга учрыг ухааран, чин сэтгэлээсээ талархан алдагдсан Бурханы дүр төрхийг төгс олж авахыг хүсэж байна.

2. Есүс амьдралынхаа бүх хугацаанд ядуу тарчиг амьдрал байсны учир шалтгаан

Есүс бол бүх хаадын Хаан, бүх эздийн Эзэн бөгөөд Бүтээгч Бурханы нэгэн хэсэг билээ.

(Иохан 1: 3д “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” гэж

мөн (Иохан 3:35)д “Эцэг нь Хүүгээ хайрлан, Түүний гарт бүх юмсыг өгсөн юм.” хэмээн айлдсанчлан бүх юмсын Эзэн болсон Есүс нь тэнгэр дэх бүх л алдар шог жавхлангаа орхин, энэ хатуу ширүүн энэ дэлхий дээр ирэн, оронд бус малын саравчинд төрсөн билээ. Тэгээд ийм нөхцөл байдалд төрөөд ч зогсохгүй амьдралынхаа бүх л хугацаанд ядуу тарчиг амьдарсан билээ.

Бидэнд амьдрах орон байр байгаа ч тухайд үед бидний Эзэнд толгой хоргодох газар ч байхгүй байсан юм.

Тиймээс Матай 8:20-д, “Есүс-Үнэг нүхтэй, тэнгэрийн шувууд үүртэй байдаг. Харин Хүний Хүүд толгой хоргодох газар байхгүй гэлээ” хэмээн айлдсанчлан Бурханы хаанчлалыг гунхаглан өвчтэй хүмүүсийг эдгээн явахдаа орогнон хонгодох газар ч байдаггүй байв. Энд тэнд шилжин явсаар заримдаа өлсөж, цангаж, зарим үед амрах ч завгүй Бурханы сургаалыг гунхагласаар явсан билээ.

Энэ мэт агуу тэмдэг гайхамшиг болон хүмүүсийн өвчнийг эгцэж байсан Тэрээр яагаад ядуу тарчиг амьдралаар амьдарсан юм бол?

Есүс баян амьдрах чадваргүй байсан болохоор ядуу тарчиг байсан биш юм. Хүсэх л юм бол Тэрээр бүх талаар элбэг дэлбэг баян амьдрах бүрэн хүч чадалтай юм. Жишээ нь усыг усан үзэмийн дарс болгон хувиргаж, 5талх 2тон загасаар 5000-с илүү хүмүүсийг цадтал хооллож, үлдэгдлийг нь цуглуулахад 12 сагс болсон балхам тэмдгийг үйлдэж, мөн элч Петр Есүсийн тушааснаар загас барин амыг нь нээхэд түүн дотроос мөнгө гарч ирдгийг харж болно. Эзэн Өөрийнхөө төлөө энэ мэт хүчийг ашигласан бол юугаар ч дутагдахгүй элбэг баян амьдрах боломжтой байсан юм. Тэгвэл Есүс яагаад бүх л амьдралынхаа туршид ядуу тарчиг утга учир нь бидний төлөө Тэрээр ядуу тарчиг байдлыг туулан, бидэнд баян байдлын ерөөлийг өгсөн юм.

Тийм ч учраас 2 Коринт 8:9-д, “Учир нь та нар бидний Эзэн Есүс Христийн нигүүлслийг мэднэ. Хэдийгээр Тэр баян байсан боловч Өөрийнхөө ядуурлаар та нарыг баян болгохын тулд та нарын төлөө Тэр ядуу болжээ.” хэмээн айлдсан байдаг ба Есүс бидэнд элбэг баян сайхан амьдралыг бий болгохын тулд Өөрөө ядуу амьдралаар амьдарсан билээ. Хүн анхнаасаа ийм ядуу тарчиг байсан биш юм. Едэн цэцэрлэгт амьдрах байхдаа бүх л хангалттай байсан юм.

Гэвч тэрээр гэм нүгэл үйлдсэний дараа хүн төрөлхтөнтэй хамт бүх л түмэн бодис хараал хүртэж, газар дэлхий дээр өргөгт бут ургамал ба халгай ургадаг болж, мөн хүн дуслуулан байж, үр тарналж, ажиллаж, хөдөлмөрлөсний эцэст түүнийхээ үр жимсээр амь зуух болсон билээ. Үүн шиг хүн төрөлхтөн ядуу тарчиг байдлыг туулдаг гол утга учир нь Адамын гэмээс болж хараал хүртсэн учраас юм. Мэдээж ядуу байдал нь гэм нүгэл биш боловч эцэстээ Адамын гэм нүгэлээс болсон хараалын нэгэн хэсэг юм.

Зарим хүмүүс Бурханаас эд баялаг гуйх нь буруу үйлдэл хэмээн үзэж байдаг боловч Библи дээр Бурхан бидэнд өрөөл болон элбэг дэлбэг байдлыг амласан байдаг. Мөн түүнчлэн, итгэлийн өвөг дээдэс болсон Абрахам, Исаак, Иаков, Иосеф болон Даниел нь Бурханаас эмээн хүндэтгэн Түүний үгийг дуулавартай дагадаг амьдралынхаа туршид тэмдэглэгдсэн байдаг билээ.

Тиймээс Есүс Эзэн Өөрөө бидний ядуу тарчиг байдлыг туулснаараа биднийг ядуу байдалаас гэтгэлгэн гаргаж, бидний элбэг баян байдлыг эдлэх боломжтой болсон билээ. Тиймээс Есүст хүлээн авч, итгэлийн амьдралаар сайн амьдарснаараа баялаг элбэг дүүрэн болсноороо Бурхандаа алдрыг өргөх боломжтой юм. Мэдээж мөнгөний шуналт хүсэлдээ автан эд баялагт улайран шунах нь зохисгүй хэрэг бөгөөд харин үүний оронд Бурханаас өгөгдсөн эд баялагийг Бурханы хаанчлалын төлөө, сайн мэдээ гараан түүгээх үйл ажиллагааг дэмжих, сүм чуулганы байр барьж байгуулахад зарцуулбал зохистой юм.

Ингэж Бурханы хаанчлалын төлөө ашиглахын төлөө гуйснаар та ерөөлийг хүртэж, мөн үүнчлэн зарцуулснаараа тэнгэрийн оронд эрхэм агуу шагналуудыг хураах болдог.(Матай 7:7-11)

Мөн түүнчлэн 3 Иохан 1:2-д, “Хайрт минь, сэтгэл тань амар тайван байгаагийн адил бүх зүйл тань сайн сайхан байж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна.” хэмээн айлдсан байдаг ба “бүх зүйл маань сайн сайхан байхын тулд бид өөрсдийн сүнс сэтгэлээ хөгжүүлэн сайн байлгах хэрэгтэй. Сүнс сэтгэлээ сайн байлгана гэлэг бол Бурханы үгийн дагуу амьдарснаар бид алдагдсан Бурханы дүр төрхийг эргүүлэн сэргээхийг хэлж байгаа юм.”

Дэд Хууль 28:2-д, “Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байвал эдгээр бүх ерөөл чам дээр бууж, чамд хүрнэ,” хэмээн айлдсан байдаг.

Бурханы үгээр эрхэм та амьдрах байгаа ч гэсэн эрхэм та Бурханы ерөөлүүдийг хүлээн авахын тулд итгэлийн үйлс хэрэгтэй юм (Галаг 6:7).

Мөн 2 Коринт 9:6-д, “Тэгэхлээр ийм байна. Хармыг тарьдаг хүн хармыг хураана. Өгөөрөөр тарьдаг хүн өгөөрөөр хураана.” хэмээн хэлэн итгэлтэй хүн ч гэсэн өгөөрөөр тарихын чухлыг энд өгүүлж байна.

“Өгөөрийг бий болгох” гэдэг нь Бурхан биднийг үнэн зүрх сэтгэлээсээ өргөсөн өргөлийг ноунаас илүүтэйгээр хүлээн авдаг билээ. Есүс нэгэн бэлэвсэн эмэгтэй хоёр эзэн зоосыг өргөлд өргөж байгаж хараад тэр эмэгтэй “Энэ бэлэвсэн эмэгтэй та нараас хавьгүй ихийг өргөлөө” гэж айлдаж “Тэрбэр өөртөө хамгаан хамаг бүх мөнгөө Бурханд өргөн барьж байна” хэмээн магтсаныг харж болно.

Бурхан бидний зүрх сэтгэлээсээ үйлдсэн үйлсийг л хамгаас нлүүд тооцон хүлээн авдаг тул та “Би ядуу тул өргөл өргөх боломжгүй” хэмээн хэлсний хэрэгтэй юм. Мэдээж эрхэм та өгөөрөө зүрх сэтгэлээр хандан өргөх болгонд Бурхан танд эргүүлэн төлдөг юм.

Харь үндэстэн зуутын дарга Корнел хүртэл Бурханыг хүндэтгэн Иудей хүмүүст сайн хандаж, их тусламж өгч байсан ба үүнийхээ хариуд тэр бүлээрээ аврал хүртсэн тухай, мөн Табита (Доркас хэмээхдэх) нэгэн эмэгтэй Бурханыг чин үнэнч сэтгэлээр хайрлан дагадаг байсан тул тэр үхсэн ч элч нарын залбирлаар дахин амилалтыг хүлээн авсан юм.

Хайрт итгэгч ах эгч дүү нараа, Өнөө үед араатан амьтдаас илүү харгис хатуу хүмүүс зөндөө байдаг билээ. Бурханы гайхамшигт өрөөл болон авралыг хүлээн авч боломжийг өгөхийн тулд Бурхан Өөрийн цорын ганц Хүүгээ энэ дэлхийд илгээн малын саравчинд төрүүлэн ядуу зүдүү амьдралаар амьдруулсан билээ.

Тиймээс бид энэ Бурханы гайхамшигт төлөвлөгөө болон Эзэн Есүсийн хайр нэрэл ба Түүний бидний төлөө хийсэн болгонд талархан, Бурханы чин үнэнч хүүхэд нь болгоон сүнс болон бие махбодийн гайхамшигт ерөөлийг хүлээн авахыг Их Эзний нэрээр хүсэн өрөө!

Хайрт итгэгч ах эгч дүү нараа, Өнөө үед араатан амьтдаас илүү харгис хатуу хүмүүс зөндөө байдаг билээ. Бурханы гайхамшигт өрөөл болон авралыг хүлээн авч боломжийг өгөхийн тулд Бурхан Өөрийн цорын ганц Хүүгээ энэ дэлхийд илгээн малын саравчинд төрүүлэн ядуу зүдүү амьдралаар амьдруулсан билээ.

Mongolian	
Манмин Мэдээ Published by Манмин Төв Сүм	
235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул, 152-848 Солонгос Улс Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048 http://www.manmin.org/english e-mail: manminministry@hotmail.com	
Нийтлүүлэгч: Жаерок Лее Редактор: Геумсун Вин	

‘Шаолин болон Хүчит нударга’ кино ба ойролцоогоор 200-гаад кинод тоглосон алдарт кино жүжигчний гэрчлэл

“Дэлхийн гэрэл ба давс болохыг би хүсч байна”

Жо Чун ахлагч (1-р их тойрог 6-р бүлэг)



“А” Аавыгаа би ажилаа яваххаас нь өмнө хацар дээр нь би үнсэнэ. мб. мб. мб 卍”
Энэ дууны ая нь дээр үед МБС телевизийн хүүхдэд зориулсан “Мб мб мб” хэмээх нэвтрүүлгийн сүлд дуу байв. Би эгч нарын тусламжтайгаар би 25 настай байхдаа урлагийн ертөнцөд хөл тавьж жүжигчин болсон юм. Би 5 эгчтэй бөгөөд эгч нар маань Солонгосын эмэгтэйчүүдийн үндэсний хөгжмийн хамтлагийн гишүүн байлаа. Ялангуяа миний дөрөв дэх эгч Жо Гөм аен эгч маань Солонгосын эмэгтэйчүүдийн үндэсний хөгжмийн өв залгамжилсан гавьяат хэмээх өргөмжлөлттэй билээ.

Машинтайгаа осолд орох үед “Миний гараас барь” гэсэн дуу хоолойг сонсож Эзэнтэй уулзсан нь
1973 онд “Улаан Жанжин” хэмээх киноны халзан дүрд тоглосноос хойш хүмүүсийн анхаарлыг ихэд татах болсон юм. Үүний дараа би маш олон туслах дүрүүдэд тоглодог байв. Тэр үед би жүдо, таеквондо болон хапкидогийн хар бүстэй болон бие хамгаалах урлагийн тэмээнд хоёрдугаар байранд орж байсан тул би жүжигчдийг дасгалжуулан заах болон зарим тохиолдолд бие хамгаалах урлагийн тулааны тоглолтонд оролцдог байв.

“Шаолин ба Хүчит нударга” болон “Супер Хонг Гил-Донг” хэмээх киноны дүрд тоглох оролцож байсан ба хүмүүст МБС телевизийн “Мб. мб. мб” болон “Еун-Гуяа! Еунг-Гуяа!” хэмээх дүрүүдээрээ алдаршсан билээ.

Би Эзэнтэй 1987 оны Нэгдүгээр сард маш их нас орсон нэгэн өдөр уулзсан юм. Охиныхоо их сургуульд орох шалгалтанд бэлтгэж, шалгалтын газар охиноо хүргэж өгөөрөө машинаар явж байлаа. Кёонги Догийн хаалга дөнгөж өнгөрөөд явж байтал мөсөн дээр машин маань гулгаж эхэлсэн ба миний ард явж байсан машин биднийг араас маш хүчтэй хүрч ирж мөргөв. Миний машин ч аюулгүйн хамгаалалтын ханлагыг давтал шидэгдэн онхилдож эргэлдэж байхад “Миний гарнаас барь” хэмээн хэлж нэгэн дугуй сонссон ба нэгэн цагаан гар гарч ирэв. Тийнхүү хэлэхийг даган гараас барьтал цаашир минь зогссон юм. Тэрхүү хамгаалалтын хашааны цахан талд 5 метр доош эгц хадан хавцал байсан тул маш их аймшигтай зүйл болох байв.

Сүнсний нүд нээгдэж минь Ариун Сүнсний галыг мэдэрсэн юм.

Би энэ осол болсноос хойш би сүмд явж эхлэв. Хэдий тийм ч гэсэн, би жүжигчин хүн тул дэлхий хүсэлдээ автаж Амралтын өдрийг төгс ариунаар сахиж чадахгүйгээс болж хамгаалалт ч гэсэн хүртэж чадахгүй, үүнээс хойш хэд хэдэн удаа машины авто осолд орсон юм. Үүний дараа би Амралтын өдрийг боломжийнхөө хэрээр сахих гэж ихэд ихчээж байсан ч байнга ийшээ тийшээ явдаг байсан болохоор тогтмол явдаг сүм байхгүй байв.

Би Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах үйл ажиллагаанд оролцогтоо маш их баярладаг. 2010 оны Тавдугаар сард миний нэгэн танилын тусламжтайгаар би Манмин Төв Сүмд хүрч ирэв. Анх удаа энэ сүмд ирж мөргөлд оролцсон өдрийг хэзээ ч мартахгүй. Бурхан миний сүнсний нүдийг түр зуур нээн онцгой ивээлийг мэдрүүлж өгсөн юм. Тэр өдөр И Жаерок тэргүүн пасторыг индэр дээр гарч ирэн зогсоход түүний өндөр нь 1м 90см орчим харагдаж байсан ба бас түүнээс гэрэл цацарч байхыг би харсан юм. Мөн түүнчлэн, Доктор И Жаерок пастор намайг тэнд цугларсан байсан арван мянга орчим итгэгч

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаая (Том хүний баг хариуцагч)
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00	Хүүхдийн мөргөл	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)
Сургагч залуучуудын мөргөл	Хлагс сайн өдөр 16: 30	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)

нарт хандан намайг зарлахад энэ нь надад үнэхээр гэнэтийн гайхамшигт үйл явдал байсан юм.

Мөргөлийн дараа би Доктор И Жаерок пасторыг маш ойрхноос харан бас дахин их гайхав. Тэрээр бараг 70 настай боловч надад маш залуу хүн шиг санагдаж, мөн түүний цэвэр цэгцтэй, намбалаг даруухан дүр төрхийг хараад сэтгэл ихэд хөдлөв. Тэгээд түүнтэй ярилцсаны дараа би өвдөг сөгдөж, толгой дээр минь гараа тавин надад залбирал хийж өгөхийг гуйлаа. Залбирал авч байх үед Ариун Сүнсний гал хүчтэйгээр буун ирэхийг мэдэрсэн юм.

Манмин Төв Сүмд би дахин шинэ итгэлийн амьдралаар

Түүний дараа би Эзний ариун өдрийг тэсэн ядан хүлээж байлаа. Эзний өдөр болж би сүмдээ очин Их мөргөлийн цагаар Доктор И Жаерок пастор завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйг уучлан, Есүс газар дээр хуруугаараа ямар нэгэн зүйл бичиж байсны тухай сүнсний утгыг тайлбарлан ярьж байв.(Иохан 8-р бүлэг) Би итгэлийн амьдралаар 23 жил амьдарч байсан ч энэ хугацаанд ганц ч удаа ийм сүнслэг сонсож үзээгүй тул их ивээл хүртсэн юм.

Тэгээд би үлдсэн амьдралаа Манмин Төв Сүмд өнгөрүүлэе гэж хатуу шийдэн 2010 оны Тавдугаар сарын 23-нд гишүүнээр бүртгүүлээ. Итгэлийн амьдралын хамгийн чухал зүйл нь Эзний зүрх сэтгэлийг дуурайх явдал гэдгийг ойлгож эхлэв. Мөн залбирлын хир чухлыг олж мэдэж, орой болгон Даниелын залбирлын цагт оролцон залбирал хийгэд хүн болсон юм. Өмнөх амьдралаа эргэн дурсаж, мөн гэмшил ба талархлын нулимсыг өөрийн эрхгүй дуслуулсан ивээлт мөчүүдийг өнгөрүүлж байна.

Манмин Төв Сүмд ирснээс хойш Эзний хайрыг улам ихээр мэдрэх болов. Ялангуяа Зуны цуглааны үеэр, сононуудаар дамжуулан сүнсний ертөнцийг оршин байдаг тухай мэдэж авсан юм. Тэдгээр сононууд нь миний болон тэнд цугларсан иршээсэн итгэгч нарын гар болон толгойн дээр нь суусвар л байсан нь маш гайхалтай байлаа. Мөн тэр сононуудын ачаар бид ямар ч шумуул болон ялаануудыг ч олж харгахгүй байсан ба энэ нь үнэхээр аз жаргалтай хормууд байсан юм.

Миний эхнэр сүмд ирэх болж, охин минь Эдгээгч Бурхантай уулзав

Мөн талархалтай зүйл нь удаан хугацаанд сүмд яваагүй эхнэр маань өнгөрсөн оны 10-р сард манай сүмийн ойн баяраар ирснээс хойш сүмд явж эхлэв. Түүний дараа долоо хоногоос эхлэн охин минь сүмд ирж И Жаерок пасторын залбирлыг авсны дараа Менунар синдром гэдэг өвчнөөсөө элдэрсэн билээ.

Би ч гэсэн сүмд явдаг болсноос хойш эрүүл саруул болж, өөрийн үг яриа, биеэ авч явах байдлаа өөрчилж байгаа билээ. Үргэлж халуун дотроон ханддаг итгэгч нар, хүмүүсийн төлөө үргэлж хайр ба сайныг сургамжлан захиж, нулимс урсган сургаал айлдах И Жаерок тэргүүн пастор, тэнгэрийн орныг үзэсгэлэнтэй сайхнаар дүрээлдэж магтаал дуу бүжгийн багууд, энэ бүхэн бүгд Эзний хайрыг мэдрүүлдэг тул сүмдээ байнга баймаар байна.

Саяхнаас 20, 50 болон 100 цуврал ангит киноны